



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/175

Булган сум

Г “Харилцан хүндэтгэе” уриа дор сарын аяныг Г зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1.6 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны IV Хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”, “Монгол цэргийн өдөр”-ийг угтан аймгийн хэмжээнд “Харилцан хүндэтгэе” уриа дор сарын аяныг зохион байгуулсугай.

2. Сарын аяныг зохион байгуулахад шаардагдах 2,560,000 (хоёр сая таван зуун жаран мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөтөлбөр” хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Наранбаяр)-т зөвшөөрсүгэй.

3. “Харилцан хүндэтгэе” сарын аяныг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
03 дугаар сарын 26-ны/ний өдрийн А/М/А/5 дүгээр
захирамжийн хавсралт

“ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР” “МОНГОЛ ЦЭРГИЙН
ӨДӨР”- ИЙГ УГТАН АЙМГИЙН ХЭМЖЭЭНД “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ” САРЫН АЯНЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1.	Эмэгтэй удирдлагуудад хүндэтгэл үзүүлэхэд:	20 хүн	85,000	1,700,000
2.	Эмэгтэй удирдлагуудад зоог бэлдэх	20 хүн	18,000	360,000
3.	Охид, хөвгүүдтэй уулзах арга хэмжээнд хэрэглэгдэх гарын авлага	200 ш	2,500	500,000
Нийт				2,560,000